

ЭМ ЗҮЙЧ МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦАГЧДЫН СУРГАЛТЫН ОРЧИН ДАХЬ СЭТГЭЛ ХАНАМЖ БА СУРЛАГЫН АМЖИЛТЫН ХАМААРАЛ

Шинэзаяа Д¹, Оюунгоо Б² Даваадагва Д³,
 АШУУИС-ТӨСА¹
 АШУУИС-СУВИЛАХУЙ²
 АШУУИС-ЭЗС³
 shinezaya@mnums.edu.mn

Хураангуй

Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд сургалтын орчны үнэлгээ чухал байр суурийг эзэлдэг бөгөөд оюутнаар сургалтын орчинг үнэлүүлэх нь сургуулийн багш, ажилчдад сургалтын чанарыг үнэлэхэд ач холбогдолтой төдийгүй сургалт болон сургалтын орчны өөрчлөлтийг аль алийг нь хэмжих боломжтой. Суралцагчдыг сэтгэл ханамжтай байхад нөлөөлдөг, тэднийг идэвхжүүлдэг хүчин зүйлсийг мэдсэнээр сургууль мэдээллийн чухал эх үүсвэртэй болж, оюутнуудад тохирсон идэвхжүүлэлтийн аргыг хэрэглэх боломжтой болох юм. АШУУИС-ийн “Эм зүйч” мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сургалтын орчин дахь сэтгэл ханамжийг тодорхойлж, түүнийг оюутны голч дүнд нөлөөлж буй байдлыг судлахад оюутнуудын сургалтын орчин дахь сэтгэл ханамж 3.4-3.8 буюу дунджаас дээгүүр утгатай байсан нь оюутнууд сургалтын орчиндоо сэтгэл ханамжтай байгааг илтгэж байна. ($p < 0.05$) Мөн оюутнуудын сургалтын орчин дахь сэтгэл ханамжийн түвшин нь сурлагын голч дүнтэй шууд, сул, шугаман хамааралтай байсан. Сургалтын хөтөлбөрийн талаарх сэтгэл ханамж, багшийн заах арга зүйн талаарх сэтгэл ханамжийг тус бүр 1 оноогоор нэмэгдүүлэхэд голч дүн 0.364, 0.307-оор тус тус өсөх хандлагатай байгаа нь харагдаж байна. Иймээс оюутны сурлагын амжилтанд багшийн заах арга зүй болон хөтөлбөрийн агуулга хамгийн их нөлөөлдөг байна.

Түлхүүр үгс: сургалтын орчин, сэтгэл ханамж, сурлагын амжилт

Үндэслэл: Манай орны хувьд дээд боловсролын байгууллагын сургалтын үйлчилгээ, суралцагчдын сэтгэл ханамжийг судлах асуудал сүүлийн жилүүдэд судлаачдын анхаарлыг ихээхэн татах болсон. Суралцагч нь сурах орчиндоо сэтгэл ханамжтай байдлаараа дамжуулан өөрийгөө өдөөн сэдэлжүүлэх нь сурлагын амжилтанд нөлөөлж цаашдаа мэдлэг, чадвар, хандлага бүхий эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд бэлтгэгдэх баталгаа болох юм. А.М.Кравченко В.И.Слободчиков нарын “Амьд биеийн өөрийн хөгжил” номны хөгжлийн тухай онолд зааснаар “Ертөнц дэх амьд бие гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөгөөр өөрсдийн зүй тогтолын дагуу хөгжиж байдаг” ба гадаад хүчин зүйлс нь хүрээлэн буй орчны нөхцөл, дотоод хүчин зүйлс нь амьдралаас урган гарсан хувь хүний хэрэгцээ

сонирхол болно. Иймд бүх амьд биес өөрийн хэрэгцээг хангах тохиромжтой, таатай орчинд өөрийгөө удирдан чиглүүлж, хөгжүүлдэг гэсэн байдаг [А.М.Кравченко нар Хөгжлийн тухай онол].

“Сургалтын орчны талаарх ойлголт” судалгаа 1950-иад оноос хойш шинжлэх ухааны үндэслэлтэй судлагдах болсон бөгөөд эхэн үедээ сургалтын материаллаг орчинг голлодог байсан бол сүүлдээ сургалтын сэтгэл зүйн ба орчныг хамааруулан авч үздэг болсон.

Сэтгэл ханамж гэдэг нь оюутнуудын хувьд сургалтаас гарч буй чанар буюу тусламж үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг. Өөрөөр хэлбэл сургалтад хандах хандлага эерэг байгаа оюутны сэтгэл ханамжийн түвшин өндөр, хандлага сөрөг байгаа оюутны сэтгэл ханамжийн түвшин муу байдаг. Сургалтын үнэлгээний нэг чухал хэсэг нь орчны үнэлгээ байдаг. Сургалтын орчныг бүхэлд нь үнэлэхийн тулд хүлээн зөвшөөрөгдсөн, найдвартай үнэлгээний арга ашиглах нь чухал. [Kiran H S нар 2013] Сайн суралцах гэдэг нь орчин тойрноосоо мэдлэг олж авахтай зайлшгүй холбоотой. [Dosg, D нар 2014]

Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд сургалтын орчны үнэлгээ чухал байр суурийг эзэлдэг бөгөөд оюутнаар сургалтын орчинг үнэлүүлэх нь сургуулийн багш, ажилчдад сургалтын чанарыг үнэлэхэд ач холбогдолтой төдийгүй сургалт болон сургалтын орчны өөрчлөлтийг аль алийг нь хэмжих боломжтой. Суралцагчдыг сэтгэл ханамжтай байхад нөлөөлдөг, тэднийг идэвхжүүлдэг хүчин зүйлсийг мэдсэнээр сургууль мэдээллийн чухал эх үүсвэртэй болж, оюутнуудад тохирсон идэвхжүүлэлтийн аргыг хэрэглэх боломжтой болох юм. Эм зүйн сургалтад материаллаг бус буюу сэтгэлзүйн орчны шаардлага, үнэлгээтэй холбоотой судалгаа хомс байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо.

Судалгааны ажлын зорилго

АШУУИС-ийн “Эм зүйч” мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сургалтын орчин дахь сэтгэл ханамжийг тодорхойлох

Судалгааны ажлын зорилт

“Эм зүйч” мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сургалтын орчин дахь сэтгэл ханамжийн түвшинг тогтоох

Оюутны сэтгэл ханамжийн түвшин нь сурлагын амжилтад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох

Судалгааны арга зүй:

Зорилт 1 хүрээнд: Агшингийн загвараар “Эм зүйч” мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сэтгэл ханамжийг судалж гүйцэтгэсэн.

Зорилт 2 хүрээнд: Аналитик загвараар “Эм зүйч” мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сэтгэл ханамжийн түвшинг голч дүнтэй харьцуулан корреляцийн аргаар хамаарлыг судалж гүйцэтгэсэн. Мөн судалгаандаа голч дүнд нөлөөлөх хүчин зүйлсийг регрессийн шинжилгээ ашиглан хийж гүйцэтгэхийг зорьсон бөгөөд голч дүнд сургалтын хөтөлбөр, оюутны идэвх оролцоо, багшийн заах арга зүй, суралцагч хоорондын харилцаа хандлага, сургалтын материаллаг орчин зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг хэмээн таамаглал дэвшүүлсэн.

Эм зүйч мэргэжлээр 2018-2019 оны хичээлийн жилд суралцаж буй эм зүйн 3, 4, 5 болон эм зүйн шаталсан 2, 3-р дамжааны оюутнаас санамсаргүй түүврийн аргаар 214 оюутанг сонгон авсан судалгааг явуулсан.

Судалгааны үр дүн

Судалгаанд оролцогчдын 8.9% (19) нь эрэгтэй, 91.1% (195) нь эмэгтэй байсан бөгөөд тэдгээрийг насны байдлаар авч үзвэл 18-20 насны 9.8% (21), 21-23 насны 69.6% (149), 24-26 насны 9.8% (21) 27-оос дээш настай 10.8% (23) оюутан байлаа. Судалгаанд оролцогчдыг суралцаж буй дамжаагаар авч үзэхэд III дамжаа 74 оюутан /65 эмэгтэй, 9 эрэгтэй/, IV дамжаанаас 54 оюутны /50 эмэгтэй, 4 эрэгтэй/ V дамжаанаас 57 оюутны /53 эмэгтэй, 4 эрэгтэй/, ЭЗШ II дамжааны 29 оюутны /27 эмэгтэй, 2 эрэгтэй/ оюутан байлаа.

Сургалтын орчны багцад сургалтын хөтөлбөр, сургалтын уур амьсгал, оюутны идэвх оролцоо, өөрийн суралцах идэвх, багш нарын заах арга зүй, суралцагч хоорондын харилцаа, хандлага, сургалтын материаллаг орчны талаар өгсөн суралцагч нарын сэтгэл ханамжийн түвшинг хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1. Сургалтын орчны багцад өгсөн үнэлгээ

Хувьсагчид	Дундаж±С.Х	95%-ийн И.И
Сургалтын хөтөлбөр, сургалтын уур амьсгалын талаарх үнэлгээ	3.6 ± 0.5	(3.5-3.7)
Оюутны идэвх оролцоо, өөрийн суралцах идэвхийн үнэлгээ	3.4 ± 0.6	(3.3-3.6)
Багш нарын заах арга зүйн талаарх үнэлгээ	3.6 ± 0.7	(3.5-3.7)
Суралцагч хоорондын харилцаа, хандлагын үнэлгээ	3.8 ± 0.8	(3.6-3.9)
Сургалтын материаллаг орчны үнэлгээ	3.4 ± 0.8	(3.3-3.6)
Нийт	3.56± 0.8	(3.4-3.7)

Судалгаанаас харахад суралцагч хоорондын харилцаа, хандлага хэсэгт хамгийн өндөр 3.8 гэсэн үнэлгээг өгсөн суралцагч нар өөр хоорондын харилцаа хандлагадаа сэтгэл ханамж сайн байгааг илтгэж байна. Харин суралцагчдын сэтгэл ханамжийн түвшин сургалтын хөтөлбөрт 3.6, багш нарын заах арга зүйд 3.6, гэсэн үнэлгээг өгсөн нь дунджаас дээш байгааг харуулж байна. Суралцагчдын сэтгэл ханамжийн түвшин оюутны идэвх оролцоо, өөрийн суралцах идэвхт 3.4, сургалтын материаллаг орчинд 3.4 дундаж утгатай нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Хүснэгт 2. Голч дүн болон бүлэг тус бүрийн сэтгэл ханамжийн хамаарлыг судалсан үр дүн

	Голч дүн	Бүлэг				
		I	II	III	IV	V
Голч дүн	1					
I Бүлэг. Сургалтын хөтөлбөр, сургалтын уур амьсгал	0.630**	1				
II Бүлэг. Оюутны идэвх оролцоо, өөрийн суралцах идэвх	0.594**	0.514**	1			
III Бүлэг. Багш нарын заах арга зүй	0.615**	0.700**	0.594**	1		
IV Бүлэг. Суралцагч хоорондын харилцаа, хандлага	0.363	0.415**	0.447**	0.494**	1	
V Бүлэг. Сургалтын материаллаг орчин	0.431*	0.437**	0.317**	0.587**	0.523**	1

Хүснэгт 2-т үзүүлснээр эхний баганад оюутны голч дүнг сургалтын хөтөлбөртэй (0.630**), багш нарын заах арга зүйтэй (0.615**) харьцуулахад шууд, хүчтэй, шугаман хамааралтай байсан бол оюутны идэвх оролцоо, өөрийн сурацах идэвх (0.594**), сургалтын материаллаг орчинтой (0.431) харьцуулахад шууд, дунд зэргийн, шугаман хамааралтай, суралцагч хоорондын харилцаа хандлага (0.363), шууд, сул, шугаман хамааралтай байлаа. Хүснэгт 2-ын 2-р баганад үзүүлснээр бүлэг асуумжын бүлэг хоорондын корреляци хамаарлыг судлахад сургалтын хөтөлбөр нь багш нарын заах арга зүйтэй (0.700**) шууд, хүчтэй, шугаман хамааралтай, оюутны идэвх оролцоо, өөрийн суралцах идэвх (0.514**), суралцагч хоорондын харилцаа хандлага (0.415**), материаллаг орчинтой (0.437**) шууд, дунд зэргийн, шугаман хамааралтай байлаа.

Хүснэгт 3. Бүлэг тус бүрийн голч дүнтэй хамааралтай гарсан хувьсагчдын дундаж

Хувьсагчид	Дундаж±С.Х	95%-ийн И.И	Дундаж±С.Х %	95%-ийн И.И
Сургалтын хөтөлбөр, сургалтын уур амьсгал	3.8 ± 0.6	(3.7-3.9)	21.1% ± 2.7	(20.6-21.7)
Оюутны идэвх оролцоо, өөрийн суралцах идэвх	3.7 ± 0.7	(3.5-3.8)	20.4% ± 3.4	(19.8-21.1)
Багш нарын заах арга барил	3.7 ± 0.7	(3.5-3.8)	20.4% ± 2.5	(19.9-20.9)
Суралцагч суралцагчийн харилцаа, хандлага	3.8 ± 0.8	(3.6-3.9)	21% ± 3.6	(20.3-21.7)
Сургалтын материаллаг орчин	3.2 ± 1.3	(2.9-3.4)	17.1% ± 5.2	(2.9-3.4)
Нийт	3.64 ± 0.8	(3.6-3.9)	25% ± 3.48	(18.3-20.1)

Дээрх судалгаанд бүлэг тус бүрийн хамааралтай гарсан хувьсагчдын дунджийг бодож үзэхэд сургалтын хөтөлбөр, сургалтын явц, суралцагч хоорондын харилцаа хандлага хамгийн өндөр буюу 3.8 сэтгэл ханамжтай байна. Харин сургалтын материаллаг орчинд 3.2 буюу сэтгэл ханамж дунд зэрэг гэсэн үнэлгээг өгсөн байна.

Хүснэгт 4. Бүлэг тус бүрийн хамааралтай гарсан хувьсагчдыг нь голч дүнтэй харьцуулсан үнэлгээ

Хувьсагчид	Голч дүн	
	г	Р утга
Сургалтын хөтөлбөр, сургалтын уур амьсгал	0.51	0.0001
Оюутны идэвх оролцоо, өөрийгөө суралцах идэвх	0.245	0.013
Багшийн заах арга зүй	0.381	0.0001
Суралцагч суралцагчийн харилцаа, хандлага	0.241	0.014
Сургалтын материаллаг орчин	0.29	0.003


*р < 0.05

Хүснэгт 4-т бүлэг тус бүрийн хамааралтай гарсан асуултуудыг бүлгээр нь голч дүнтэй харьцуулан корреляцийн шинжилгээ хийж үзэхэд сургалтын хөтөлбөр, сургалтын уур амьсгал (0.51) , багшийн заах арга зүй (0.381) шууд, дунд зэргийн, шугаман хамааралтай байгаа бол оюутны идэвх оролцоо, өөрийгөө үнэлэх байдал, суралцагч хоорондын харилцаа хандлага, сургалтын материаллаг орчин зэрэг нь шууд, сул, шугаман хамааралтай байна. Энэхүү үр дүнд үндэслэн нэг хүчин зүйлийн регресс болон олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ хийж хүснэгт 5-т харуулав.

Хүснэгт 5. Регрессийн шинжилгээний үр дүн

Хувьсагчид	Нэг хүчин зүйлийн шугаман регрессийн шинжилгээ			Олон хүчин зүйлийн шугаман регрессийн шинжилгээ		
	Налалтын коэф	Налалтын коэф-н 95%-н итгэх интервал	Р утга	Налалтын коэф	Налалтын коэф-н 95%-н итгэх интервал	Р утга
Сургалтын хөтөлбөр, сургалтын уур амьсгал	0.357	0.238-0.476	0.0001	0.364	0.174-0.554	0.0001
Оюутны идэвх оролцоо, өөрийгөө үнэлэх хэсэг	0.153	0.033-0.272	0.013	-0.044	-0.179-0.092	0.526
Багшийн заах арга зүй	0.729	0.12-0.339	0.0001	0.307	-0.179-0.166	0.012
Суралцагч суралцагчийн харилцаа, хандлага	0.132	0.027-0.236	0.014	0.028	-0.085-0.141	0.624
Сургалтын материаллаг орчин	0.103	0.036-0.17	0.003	0.011	-0.069-0.09	0.792

Судалгаагаар нэг хүчин зүйлийн регресс болон олон хүчин зүйлийн регрессийн үр дүнг харуулсан. Нэг хүчин зүйлийн регрессийн шинжилгээгээр голч дүн буюу оюутны сурлагын амжилтад сургалтын хөтөлбөр, оюутны идэвх оролцоо, багш нарын заах арга зүй, суралцагч хоорондын харилцаа хандлага, сургалтын материаллаг орчинтой шууд, сул, шугаман хамааралтай гарсан бөгөөд үнэн магадтай эсэхийг Р утгаар баталлаа. Сургалтын хөтөлбөрийн талаарх сэтгэл ханамжийг 1 оноогоор нэмэгдүүлэхэд голч дүн 0.357-оор, оюутны идэвх оролцоо өөрийгөө үнэлэх үнэлэмжийн талаарх сэтгэл ханамжийг 1 оноогоор нэмэгдүүлэхэд голч дүн 0.153-аар, багшийн заах арга зүйн талаарх сэтгэл ханамжийг 1 оноогоор нэмэгдүүлэхэд голч дүн 0.729-оор, суралцагч хоорондын харилцаа хандлагын талаарх сэтгэл ханамжийг 1 оноогоор нэмэгдүүлэхэд голч дүн 0.133-аар, сургалтын материаллаг орчны талаарх сэтгэл ханамжийг 1 оноогоор нэмэгдүүлэхэд голч дүн 0.103-аар нэмэгдэх хандлагатай байсан бол олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээгээр голч дүн буюу оюутны сурлагын амжилтад сургалтын хөтөлбөр, багш нарын заах арга зүй шууд, сул, шугаман хамааралтай гарсан бөгөөд үнэн магадтай эсэхийг Р утгаар баталлаа. Сургалтын хөтөлбөрийн талаарх сэтгэл ханамжийг 1 оноогоор нэмэгдүүлэхэд голч дүн 0.364-оор, багшийн заах арга зүйн талаарх сэтгэл ханамжийг 1 оноогоор нэмэгдүүлэхэд голч дүн 0.307-оор өсөх хандлагатай байгааг дараах графикаар үзүүлээ. Босоо тэнхлэгт суралцагчдын голч оноо, хөндлөн тэнхлэгт сэтгэл ханамжийн үнэлгээг Зураг 1-д харуулав.



Зураг 1. Олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ

Дүгнэлт:

1. Оюутнуудын сургалтын орчин дахь сэтгэл ханамж 3.4-3.8 буюу дунджаас дээгүүр утгатай байсан. Энэ нь оюутнууд сургалтын орчиндоо сэтгэл ханамжтай байгааг илтгэж байна. ($p < 0.05$)
2. Оюутнуудын сургалтын орчин дахь сэтгэл ханамжийн түвшин нь сурлагын голч дүнтэй шууд, сул, шугаман хамааралтай байсан. Сургалтын хөтөлбөрийн талаарх сэтгэл ханамж, багшийн заах арга зүйн талаарх сэтгэл ханамжийг тус бүр 1 оноогоор нэмэгдүүлэхэд голч дүн 0.364, 0.307-оор тус тус өсөх хандлагатай байлаа.

CORRELATION OF PHARMACY STUDENT'S SATISFACTION ON THEIR LEARNING ENVIRONMENT AND STUDY SUCCESS

Shinezaya D¹, Oyungoo B², Davaadagva D³
 MNUMS-Division of Educational policy and management¹
 MNUMS-School of Nursing²
 MNUMS-School of Pharmacy³
 shinezaya@mnums.edu.mn
 Tell:88021231

In our country, research on tertiary education services and students' satisfaction is being studied more in recent years. Students will be motivated to succeed if they are satisfied with their learning environment and thus ensuring the expertise of qualified health professionals. Learning the aspects that make students feel content and what motivates them will enable the school to become an important source of information and use appropriate methods that inspire the students. Because requirements and evaluations regarding non-material or psychological environment is rare in pharmacy program, we decided to take on this research.

Our research goal is to evaluate and study the level of satisfaction of the School of Pharmacy, MNUMS student's on their learning environment. Conclusion was the student satisfaction of learning environment is 3.4-3.8 or above average. This indicates that the students are satisfied with their learning environment ($p < 0.05$). The comparison of the student's satisfaction level of their learning environment to their GPA is direct, weak and linear. The GPA is tending

to increase by 0.364 while increasing the satisfaction with the curriculum by 1 point and likewise, GPA will increase by 0.307 if the satisfaction of the teaching method is increased by 1 point.

Key words: Learning environment, grade point average (GPA), level of satisfaction

НОМ ЗҮЙ:

1. Д.Цэрэндагва, Ц.Лхагвасүрэн. Ази, Номхон далайн бүсийн болон Монголын анагаах ухааны боловсрол судлал. Анагаах ухааны боловсрол судлал. 2007:х.11.
2. Б.Балжинням ЭХ, Д.Отгонбаяр, Д.Амарсайхан. Анагаахын хөтөлбөрийн хэрэгжилтэнд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаа. Анагаах ухааны боловсрол судлал. 2013:4.
3. Bolor-Erdene O. Шугаман регрессийн загвар ба хамаарлын судалгаа МҮИС-ийн ЭЗБУС-ийн багш, магистр О.Болор-Эрдэнэ. 2019.
4. M.Epstein. R. Assessment of medical education. The new England journal of medicine. 2007:390-391.
5. Э.Хангай. Сувилахуйн сургалтын орчинд хийсэн сэтгэл ханамжийн судалгаа. 2017 он.
6. Rusticus S, Worthington A, Wilson D, Joughin K. The Medical School Learning Environment Survey: an examination of its factor structure and relationship to student performance and satisfaction. Learning Environments Research. 2014;17(3).
7. Надежда Николаевна Алова. "Подготовка и использование фармацевтических кадров (XIX- XX- XXI в.) на примере Санкт-Петербурга" Диссертация на соискание ученой степени кандидата фармацевтических наук. Санкт-Петербург, 2004.
8. Б.Бат-Өлзий. Төгсөгчдийн ур чадварыг үнэлэх шалгалтын талаарх сэтгэл ханамж. 2017.